



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/335

Чингис хот

Коронавируст халдвар (Covid-19)-ын эмчилгээ болон бэлэн байдлыг хангахад шаардлагатай зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.12, 58.1.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Онцгой комиссын 2021 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу коронавируст халдварын эмчилгээ болон бэлэн байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардлагатай 34 902 400 (гучин дөрвөн сая есөн зуун хоёр мянга дөрвөн зуу) төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгө зарцуулах тооцоог хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

07 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын ... өдрийн ... А/335
дугаар захирамжийн хавсралт

Коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангахад
шаардлагатай зардлын тооцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Шаардлагатай хамгаалах хэрэгсэл	
				Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Аюулгүйн хайрцаг	ширхэг	5480	50	274000
2	1 удаа өмсгөл	ширхэг	15000	1000	1500000
3	Нүүрний хаалт	ширхэг	2000	500	1000000
4	үзлэгийн бээлий	Хос	700	6500	4550000
5	Хогны уут	ширхэг	4800	50	240000
6	Санитол	ширхэг	7000	50	350000
7	Халдваргүйтгэл хийхэд зарцуулсан шатахуун	л	1550	1057	1638400
7	Гэрээтээр ажилласан сувилагчийн цалин	хүн	500000	2	1000000
8	Мал эмнэлгийн хөргүүрийн засварын үнэ	Удаа	300000	1	300000
9	Моргийн хөргөгч	Ширхэг	8200000	1	8200000
10	Нэгдсэн эмнэлгийн вируслогийн лабораторийн хөргүүр (air condition)	Ширхэг	2350000	1	2350000
Нийт дүн					34902400